

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын жилийн сургуулийн
2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/216/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: gansukhs@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Д.Отгонбаяр
Утас: 99385356 Цахим хаяг:
khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.АМГАЛАН ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/195
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 270,238.4 мянган төгрөгийн бараа материал, 463,912.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой 46,570.5 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал нь Боловсролын газрын даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 хөтөлбөр, 86.3 арга хэмжээний хүрээнд 86.3 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6703821573

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>386,685,449.52</u>	<u>375,517,039.17</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	191,084,978.52	139,312,875.17
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	191,084,978.52	139,312,875.17
3121	Төгрөг	191,084,978.52	139,312,875.17
31211	Төрийн сангийн харилцах	191,084,978.52	139,312,875.17
34	УРЬДЧИЛГАА	3,527,100.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	3,527,100.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	192,073,371.00	236,204,164.00
351	Түүхий эд материал	1,126,320.00	1,069,510.00
35130	Эм боох материал	1,126,320.00	1,069,510.00
354	Хангамжийн материал	186,792,051.00	231,729,654.00
35410	Бичиг хэргийн материал	10,543,050.00	8,014,230.00
35420	Аж ахуйн материал	73,514,684.04	97,814,284.04
35440	Түлш, шатах тослох материал	2,634,500.00	110,000.00
35450	Барилгын засварын материал	16,119,834.00	18,425,834.00
35460	Хүнсний материал	18,823,325.00	34,816,620.00
35470	Бусад хангамжийн материал	65,156,657.96	72,548,685.96
35600	Мал амьтад	4,155,000.00	3,405,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,443,074,216.64</u>	<u>2,740,979,561.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,443,074,216.64	2,740,979,561.08
392	Биет хөрөнгө	2,298,586,016.56	2,596,818,760.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,720,087,950.00	2,720,087,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-673,590,224.52	-766,678,523.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,875,000.08	-8,812,500.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	207,285,665.98	606,176,023.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-75,684,509.68	-117,134,081.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	146,861,902.23	138,794,217.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-69,855,031.47	-38,066,498.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,051,700.00	25,951,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,498,592.46	-11,375,145.69
39217	Ном	23,302,156.56	24,375,618.96
393	Биет бус хөрөнгө	144,488,200.08	144,160,800.12
39301	Програм хангамж	1,637,000.00	1,637,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-654,799.92	-982,199.88
39303	Бусад биет бус хөрөнгө	143,506,000.00	143,506,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,829,759,666.16</u>	<u>3,116,496,600.25</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>186,349,300.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	186,349,300.00
413	Өглөг	00.00	186,349,300.00

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4136	Бусад өглөг	00.00	186,349,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	186,349,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,829,759,666.16	2,930,147,300.25
51	Засгийн газрын хувь оролцоо	2,829,759,666.16	2,930,147,300.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	711,661,291.02	711,661,291.02
51101	Өмч: - төрийн	711,661,291.02	711,661,291.02
512	Хуримтлагдсан үр дүн	1,444,803,277.25	1,545,190,911.34
51210	Өмнөх үеийн үр дүн	1,444,803,277.25	1,444,803,277.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	100,387,634.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	673,295,097.89	673,295,097.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,829,759,666.16	3,116,496,600.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,026,026,941.17	2,806,863,897.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,437,341.17	230,099,697.30
120	Нийтлэг татварын бус орлого	17,437,341.17	230,099,697.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,345,608.70	22,843,085.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,345,608.70	22,843,085.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө	10,728,567.70	192,746,584.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материал	4,363,164.77	14,510,028.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,008,589,600.00	2,576,764,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,716,709,900.00	2,287,723,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,716,709,900.00	2,287,723,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,996,800.00	2,741,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,996,800.00	2,741,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,882,900.00	286,299,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,882,900.00	286,299,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,037,050,284.63	2,706,476,263.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,037,050,284.63	2,706,476,263.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,938,678,074.07	2,600,028,664.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,154,381,676.00	1,765,621,058.00
210101	Үндсэн цалин	870,670,102.00	1,141,716,314.00
210102	Нэмэгдэл	218,738,493.00	494,202,883.00
210104	Урамшуулал	64,973,081.00	129,701,861.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,638,644.00	218,784,050.00
210201	Тэтгэврийн даатгал	97,642,095.00	149,198,150.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,487,306.00	17,552,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,058,130.00	8,776,450.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,223,057.00	8,776,450.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,228,056.00	34,480,300.00

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	271,004,145.94	247,816,981.78
210301	Гэрэл, цахилгаан	18,575,389.94	19,004,888.78
210302	Түлш, халаалт	251,382,428.00	227,616,356.00
210303	Цэвэр, бохир ус	1,046,328.00	1,195,737.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,189,827.50	30,120,720.00
210401	Бичиг хэрэг	3,900,640.00	11,438,920.00
210402	Тээвэр, шатахуун	8,894,100.00	9,610,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,737,750.00	7,921,350.00
210408	Бараа материал акталсны зардал	26,657,337.50	1,150,000.00
2105	Нормативт зардал	94,951,965.20	97,122,283.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	872,620.00	1,644,983.00
210502	Хоол, хүнс	94,079,345.20	95,477,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,535,300.00	19,723,600.00
210604	Урсгал засвар	17,535,300.00	19,723,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,701,800.00	13,222,465.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,786,800.00	2,496,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,915,000.00	10,726,365.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,274,715.43	207,617,506.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,572,833.48	35,099,867.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,212,100.00	6,510,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	170,489,781.95	166,007,239.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,372,210.56	106,447,598.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,127,756.50	85,100,380.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,435,256.50	50,051,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,692,500.00	35,048,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,244,454.06	21,347,218.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,244,454.06	21,347,218.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11,023,343.46	100,387,634.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-11,023,343.46	100,387,634.09

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	676,390,091.02	673,295,097.89	1,455,826,620.71	2,805,511,809.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	676,390,091.02	673,295,097.89	1,455,826,620.71	2,805,511,809.62
C07	Тайлант үеийн үр дүн	35,271,200.00	00.00	-11,023,343.46	24,247,856.54
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	711,661,291.02	673,295,097.89	1,444,803,277.25	2,829,759,666.16

D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	711,661,291.02	673,295,097.89	1,444,803,277.25	2,829,759,666.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	711,661,291.02	673,295,097.89	1,444,803,277.25	2,829,759,666.16
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	100,387,634.09	100,387,634.09
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	711,661,291.02	673,295,097.89	1,545,190,911.34	2,930,147,300.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,008,589,600.00	2,594,763,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	17,999,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	17,999,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	17,999,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	17,999,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,008,589,600.00	2,576,764,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,716,709,900.00	2,287,723,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,716,709,900.00	2,287,723,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,996,800.00	2,741,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,996,800.00	2,741,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,882,900.00	286,299,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,882,900.00	286,299,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,856,665,314.48	2,616,784,903.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,856,665,314.48	2,616,784,903.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,751,291,866.42	2,510,119,805.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,152,820,829.00	1,765,621,058.00
210101	Үндсэн цалин	869,109,255.00	1,141,716,314.00
210102	Нэмэгдэл	218,738,493.00	494,202,883.00
210104	Урамшуулал	64,973,081.00	129,701,861.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,638,644.00	218,784,050.00
210201	Тэтгэврийн даатгал	97,642,095.00	149,198,150.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,487,306.00	17,552,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,058,130.00	8,776,450.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,223,057.00	8,776,450.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,228,056.00	34,480,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,638,645.94	245,292,481.78

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	18,575,389.94	19,004,888.78
210302	Түлш, халаалт	254,016,928.00	225,091,856.00
210303	Цэвэр, бохир ус	1,046,328.00	1,195,737.00
2105	Нормативт зардал	97,812,074.00	106,409,610.00
210502	Хоол, хүнс	97,812,074.00	106,409,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,999,800.00	19,660,200.00
210604	Урсгал засвар	7,999,800.00	19,660,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,701,800.00	13,222,465.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,786,800.00	2,496,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,915,000.00	10,726,365.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,680,073.48	141,129,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,352,973.48	124,909,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,327,100.00	16,220,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,373,448.06	106,665,098.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,128,994.00	85,317,880.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,478,494.00	50,269,480.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,650,500.00	35,048,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,244,454.06	21,347,218.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,244,454.06	21,347,218.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>151,924,285.52</u>	<u>-22,021,103.35</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,324,400.00	29,751,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,324,400.00	29,751,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,324,400.00	29,751,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,324,400.00	29,751,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-34,324,400.00</u>	<u>-29,751,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	117,599,885.52	-51,772,103.35
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	73,485,093.00	191,084,978.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,084,978.52	139,312,875.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	%
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		191,084,978.52	(191,084,978.52)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,497,626,100.00	2,357,739,903.35	139,886,196.65	94.4

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,497,626,100.00	2,357,739,903.35	139,886,196.65	94.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,404,556,900.00	2,272,422,023.35	132,134,876.65	94.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,816,255,200.00	1,765,621,058.00	50,634,142.00	97.2
210101	Үндсэн цалин	1,196,072,800.00	1,141,716,314.00	54,356,486.00	95.5
210102	Нэмэгдэл	530,980,100.00	494,202,883.00	36,777,217.00	93.1
210104	Урамшуулал	89,202,300.00	129,701,861.00	-40,499,561.00	145.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	227,032,000.00	218,784,050.00	8,247,950.00	96.4
210201	Тэтгэврийн даатгал	154,381,700.00	149,198,150.00	5,183,550.00	96.6
210202	Тэтгэмжийн даатгал	18,162,600.00	17,552,700.00	609,900.00	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,081,300.00	8,776,450.00	304,850.00	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	9,081,300.00	8,776,450.00	304,850.00	96.6
210205	Эрүүл мэндийн даатгал	36,325,100.00	34,480,300.00	1,844,800.00	94.9
2105	Нормативт зардал	140,677,500.00	106,409,610.00	34,267,890.00	75.6
210502	Хоол, хүнс	140,677,500.00	106,409,610.00	34,267,890.00	75.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,281,700.00	10,726,365.35	25,555,334.65	29.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,281,700.00	10,726,365.35	25,555,334.65	29.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	184,310,500.00	170,880,940.00	13,429,560.00	92.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	168,010,600.00	154,660,140.00	13,350,460.00	92.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,299,900.00	16,220,800.00	79,100.00	99.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	930,692,000.00	853,178,800.00	7,751,320.00	91.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,069,200.00	85,317,880.00	7,751,320.00	91.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,924,200.00	50,269,480.00	7,654,720.00	86.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,145,000.00	35,048,400.00	96,600.00	99.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,305,222,800.00	2,305,722,800.00	0.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,305,222,800.00	2,305,222,800.00	0.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,287,223,200.00	2,287,223,200.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,999,600.00	17,999,600.00	0.00	
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,999,600.00	17,999,600.00	0.00	100.0
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	191,903,300			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	191,084,978.52		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	139,312,875.17		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

Аудитын код: ХӨА-2025/216/НА-СТА-ТШЗ

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
	ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80111	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	286,299,900.00	264,952,681.78	21,347,218.22	92.5
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	286,299,900.00	264,952,681.78	21,347,218.22	92.5
210	Бараа, үйлчилгээний зардал	286,299,900.00	264,952,681.78	21,347,218.22	92.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	266,299,900.00	245,292,481.78	21,007,418.22	92.1
210301	Гэрэл цахилгаан	13,000,000.00	19,004,888.78	(6,004,888.78)	146.2
210302	Түлш, халаалт	250,799,900.00	225,091,856.00	25,708,044.00	89.7
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	1,195,737.00	1,304,263.00	47.8
2106	Эд хогшил худалдан авах	20,000,000.00	19,660,200.00	339,800.00	98.3
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,660,200.00	339,800.00	98.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	286,299,900.00	264,952,681.78	21,347,218.22	92.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	286,299,900.00	264,952,681.78	21,347,218.22	92.5
132001	Орон нутгийн төсвөөс	286,299,900.00	264,952,681.78	21,347,218.22	92.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 46,570.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 5 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

5.2 Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага өгөөгүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Төсвийн захирагч нь 35 багш ажилтанд нийт 28,100.6 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Илүү цагийг тооцож олгохдоо Засгийн газрын "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгт хөтлөх

2.1 Илрүүлэлт:

Тус сургуулийн захирлын 2024 оны 07 сарын 23-ны өдрийн Б/33 дугаар тушаалаар байгууллагын нягтлан бодогчид 2 сар, няравт 2 сарын үндсэн цалингаар тус тус балансын

урамшуулалд 5,026.0 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн ангилал зөрүүтэй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

2.2 Өгсөн зөвлөмж:

Балансын урамшууллыг олгох талаар дотоод журамд зааж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас олгож байх

3.1 Илрүүлэлт:

Тус сургуулийн тайлант жилийн дотуур байрны 22797 хүүхдийн ирц, хоолны нормыг тооцоолоход 869.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан зөрчил илэрсэн.

Стандартын заалт: УСНББОУС-24 Төсвийн мэдээлэл

Хууль тогтоомжийн заалт: Хоолны зардлын норматив тогтоох тухай Засгийн газрын 2022 оны 498 дугаар тогтоолын 2 дахь заалт¹, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Хоолны зардлын батлагдсан нормативыг мөрдөж ажиллах

4.1 Илрүүлэлт:

Тайланд жилд тус сургууль нь Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 169 мэдээллээс 165 мэдээллийг хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төсөл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр зориулалт зэрэг 4 мэдээллийг хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв оруулж байх

Худалдан авах ажиллагаатай холбоотой:

Илрүүлэлт:

Худалдан авалтын гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээгээр нийлүүлэлт хийгээгүй байна. Тухайлбал: Баялаг Их-уул хоршоо, Хос баян хайрхан хоршоо, "Сүлд бумбат" ХХК-тай тус тус хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай гэрээ байгуулж, хүлээн авсан нэр төрөл, тоо хэмжээнээс илүү, дутуу нийлүүлсэн, нэмж гэрээгүй худалдан авалт хийсэн 12,450.5 мянган төгрөгийн илэрч байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн зохион байгуулж, тайлагнах

Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

¹ "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 төгрөгөөр, бага, дунд ангийн нэг сурагчийн хоногийн хоолны зардлыг 4000 төгрөгөөр тогтоосугай"

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулаагүй, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэрэл цахилгааны зардлаас эрчим хүчний алдангийн төлбөр	1	123.6	1	123.6				
Нотлох баримтгүйгээр илүү цагийн нэмэгдэл олгосон нярав, нягтланд блансын урамшуулал олгосон	1	5,026.0					1	5,026.0
Төсвийн захирагч нь 35 багш ажилтанд нийт 28,100.6 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөөгүй	1	28,100.6					1	28,100.6
Дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны норм нормативыг тууштай мөрдөөгүй байна	1	869.8					1	869.8
Дүн	3	34,120.0	1	123.6			3	34,120.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 169 мэдээллээс 165 мэдээллийг							1	0

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн									
Дүн								1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Худалдан авалтын гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээгээр нийлүүлэлт хийгээгүй байна	1	12,450.5						1	12,450.5
Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй.	1	0						1	0
Дүн	2	12,450.5						2	12,450.5
Нийт дүн	2	12,450.5						2	12,450.5